



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/23

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
дуудлага худалдаа зохион байгуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлах тухай” тушаал, МУ-ын Засгийн газар 2024 оны 136 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх газрын анхны үнэ, хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад заагдсан 10 нэгж талбарыг газрын биржийн программ хангамжаар нийтэд зарлан цахим хэлбэрээр 2024 оны 7-р сарын 2-ны өдрийн 09 цагт товлож, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг газрын газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.ОДГЭРЭЛ